



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 1/49

Алтай хот

**Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл  
мэдээллийн сан бүрдүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.9.3, 29.9.9, 29.13.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд байгууллага бүр ажиллах хүч, түүний хөдөлгөөний талаарх мэдээллийг сар бүр, сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг тухай бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж, бүртгэлтэй ажил хайгч иргэдийг ажлын байраар ханган ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай

2.25 ба түүнээс дээш ажилтантай байгууллага, аж ахуйн нэгж нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулахыг үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Л.Отгончимэг), хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Д.Баттайван), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

